

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 67 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт



**“ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ”
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9-д “иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, ажлыг зохион байгуулж, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг тайлбарлан таниулах” ИТХ, Тэргүүлэгчдийн бүрэн эрхийг, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”-д хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах; 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “е”-д “Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын үйл ажиллагааны талаар хүн амыг үнэн зөв мэдээллээр хангах” бүрэн эрхийг тус тус заасан байна.

Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн 39-т “Бүх нийтийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх, иргэдэд улс төрийн болон эрх зүйн соёлыг эзэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төрийн бүх шатны байгууллагаас явуулна. Үндсэн хуулийн зарчим, үзэл санааг иргэн бүр чанд хэрэгжүүлэх үзлийг бага наснаас нь төлөвшүүлэхийг гол зорилго болгон, эрх зүйн сурталчилгаа, мэдээлэл, сургалтыг Үндсэн хууль, бусад хуулийг тууштай биелүүлэхэд чиглүүлнэ” гэж, Засгийн газрын 1993 оны 57 дугаар тогтоолоор нийтийг хамарсан эрх зүйн сургалт зохион байгуулах, албан болон албан бус сургалт, мэдээллийн хэрэгсэл ашиглан хууль тогтоомжийг сурталчлах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхээр заасан байдаг.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Хууль тогтоомжийг сурталчлах тайлбарлан таниулах, эрх зүйн сургалт сурталчилгаа мэдээллийн ажлыг тогтмол явуулж, иргэдийн нийгмийн амьдралд оролцох эрх, үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ” /4.4.2/, “Аймгийн хэмжээнд зохион байгуулах эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг нэгдсэн хөтөлбөр,

удирдамжийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлж, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ” /4.4.2.1/. “Хууль, журам-миний амьдралд” аяны хүрээнд хууль эрх зүйн мэдээлэл түгээх ажлыг иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэдийн эрх зүйн мэдлэг, соёлын түвшнийг ахиулна” /4.4.2.2/ гэсэн зорилтууд нь хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх үндэслэлүүд болно.

Захиргааны байгууллагуудаас төрийн хууль тогтоомжууд, аймгийн ИТХ, Засаг даргаас гаргасан шийдвэрүүдийг биелүүлэхдээ тэдгээрийг юуны өмнө иргэд, олон нийтэд сурталчлах талаар хуулиар хүлээсэн үүргээ сайтар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иргэд нийгмийн аливаа харилцаанд оролцохдоо дагаж мөрдвөл зохих хэм хэмжээг мэддэггүйгээс болж эрхээ эдэлж чадахгүй ямар нэгэн байдлаар хохирох, үүргээ үл биелүүлснээс болж нийгмийн дэг журам зөрчих, улмаар гэмт хэрэг үйлдэх, захиргааны зөрчил гаргах явдал байсаар байна. Сүүлийн 2 жилийн гэмт хэргийн бүртгэл судалгаанаас харахад аймгийн хэмжээнд согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 197, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 52, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 25, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 371, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 221, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 16, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 89 тус тус бүртгэгдсэн байна.

Иймд иргэдэд хууль тогтоомжоор олгосон эрхийг нь ойлгуулах тэдгээрийг бүрэн, зөв эдлэх боломж бүрдүүлэх, хууль тогтоомжоор хориглосон үйлдлийг гаргахгүй байхын утга учрыг тайлбарлан таниулах ажлыг байнга тасралтгүй, үр нөлөөтэй явуулах нь тэдгээрийн эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Иргэн хүн хуулиар баталгаажсан эрхээ мэдэх түүнийгээ бүрэн эдлэх мэдлэг чадвартай болсноор төрийн үйлчилгээг тэгш хүртэх боломжтой болох, мөн хуулиар хүлээсэн үүргээ мэдэж түүнийг зөрчихгүй байх нь аливаа хэрэг зөрчилд холбогдохгүй байх, төрийн үйлчилгээ, хуулийн байгууллагад итгэх итгэл нэмэгдэх, өөртөө итгэх итгэлтэй болох, ядууралд хүргэх хүчин зүйлүүдээс ангид байх арга замаа мэдэх зэрэг бусад олон эерэг үр нөлөө үзүүлж улмаар иргэдийн амьдралын чанарт сайнаар нөлөөлөх ач холбогдолтой юм.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1.Хөтөлбөрийн зорилго

Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрх зүйн анхан шатны мэдлэгийг олгох, сургалт, сурталчилгаа, мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр хүргэх замаар иргэдэд хуулиар олгосон эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх чадвар, хандлага бий болгон төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2.Хөтөлбөрийн зорилтууд

Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

2.2.1.Иргэдэд эрх зүйн мэдлэг олгох албан болон албан бус сургалтуудыг тогтмол зохион байгуулах, эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэх

2.2.2.Хууль тогтоомжийг тайлбарлан таниулах сурталчилгаа мэдээллийн ажлыг үе шаттай явуулж, үр нөлөөг дээшлүүлэх, эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай техник, санхүү, хүний нөөцийг бүрдүүлэх, тогтсон мэдээллийн сувгуудыг бий болгон тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.

2.2.3.Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд олон талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулах

2.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

2.3.1.Хөтөлбөрийг 2019-2023 он хүртэл 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1.Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1.Эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны агуулгыг бэлтгэх, түгээх чиглэлээр батлагдсан арга зүйн дагуу сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг зохион байгуулах

3.1.2.Эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг эзэмшүүлэх эрх зүйн шаталсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх,

3.1.3.Иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан зорилтот бүлэгт тухайлбал, харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэн, өндөр настан, хүүхдэд ээлтэй, тэдгээрийн нас, сэтгэхүйн онцлог, нийтлэг болон тусгай хэрэгцээ шаардлагад нь тохирсон эрх зүйн боловсролын агуулгыг боловсруулах

3.1.4.Хууль, захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шийдвэрийг бүрнээр нь болон хэсэгчлэн ангилсан байдлаар иргэдэд хүргэх, сурталчлах, эрх зүйн мэдээллийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх

3.1.5.Хууль зүйн туслалцааны төвөөс зорилтот бүлгийн иргэдэд эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, зорилтот бүлэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хууль зүйн туслалцааны чанар, хүртээмжийг сайжруулах

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1.Эрх зүйн хөтчийг гэрээгээр ажиллуулах /Сум, баг, төрийн болон төрийн бус байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд мэргэшсэн эрх зүйн хөтөч ажиллуулах/

3.2.2.Эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, судалгаанд мэдээллийн технологийг ашиглах, орон нутгийн телевиз, хэвлэлийнхэнтэй хамтарч ажиллах

3.2.3.Хууль, эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, зөвлөгөөний цахим хуудас ажиллуулах, мэдээлэл сурталчилгааг тасралтгүй хүргэх

3.2.4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, хүүхдэд эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх хүний нөөц (дохионы хэлний хэлмэрч, сэтгэл зүйч)-ийг бэлтгэх ажилд холбогдох байгууллагад нь дэмжлэг үзүүлэх

3.2.5.Сумдын Засаг даргын Тамгын газрын эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах, мэргэжил, арга зүйгээр хангах

3.3.Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1.Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр орон нутгийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх

3.3.2.Эрх зүйн болон хүний эрхийн сургалт, сурталчилгаанд орон нутгийн төрийн байгууллагууд, Хууль зүйн туслалцааны төвийн орон нутаг дахь салбар болон бусад холбогдох этгээдийн оролцоог нэмэгдүүлэх, чиглэл өгөх, үйл ажиллагааг уялдуулах

3.3.3.Эрх зүйн мэргэжлээр сургалт явуулж буй Ховд их сургууль болон төрийн бус байгууллагуудын дэргэдэх хууль зүйн клиник төвөөс иргэдэд эрх зүйн болон хүний эрхийн анхан шатны зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, чадавхжуулах, эрх зүйч мэргэжлээр сурч буй оюутнуудын эрх зүйн хөтчөөр ажиллах сайн дурын үйл ажиллагааг бүх талаар дэмжих

3.3.4.Эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгааны ажилд төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах

3.3.5.Бүх нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд үүрэн холбооны аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг хариуцлагыг өндөржүүлж, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх зүйн болон хүний эрхийн мэдээлэл, сурталчилгааны ажилд оролцохыг бүх талаар дэмжих

3.3.6.Тодорхой түвшний эрх зүйн мэдлэг эзэмшсэн хамт олон болж, үүнийгээ үнэлүүлэн баталгаажуулахад чиглэсэн санал, санаачилга өрнүүлэх арга хэмжээг зохион байгуулах

3.3.7.Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжигч, бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох үүргээ сайн хэрэгжүүлсэн байгууллага, хамт олныг сурталчлах, алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулах.

Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

4.1.Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө:

4.1.1.Иргэд хаана, ямар нөхцөлд амьдарч байгаагаас үл хамааран эрх зүйн үйлчилгээ, мэдээллийг саадгүй авах нөхцөл бүрдэнэ;

4.1.2.Иргэд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо хуулийн хүрээнд хамгаалах, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх чадвар, боломж нэмэгдэнэ;

4.1.3.Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо нэмэгдэж, төрийн байгууллагаас гарах аливаа шийдвэр нь хүний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчихгүй байх нөхцөл бүрдэнэ;

4.1.4.Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, иргэдийн оролцоо, дэмжлэг сайжирна;

4.1.5.Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх иргэдийн эрх зүйн ухамсар дээшилнэ.

4.2. Хөтөлбөрийн эдийн засгийн үр нөлөө:

4.2.1.Иргэд эрхээ эдлэх, баталгаажуулах боломж бий болсноор амьжиргаагаа дээшлүүлэх бололцоо нэмэгдэнэ;

4.2.2.Иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалах, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх иргэдийн чадвар нэмэгдсэнээр бусдын буруутай үйл ажиллагааны улмаас учрах эдийн засгийн хохирол буурна;

4.2.3.Эрх зүйн мэдээлэл, хууль зүйн туслалцаа үзүүлэх цахим сүлжээг нэвтрүүлснээр эрх зүйн мэдээлэл, туслалцаа авахад хялбар болж, зардал буурна;

4.2.4.Хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх иргэдийн ухамсар дээшилснээр гэмт хэрэг, зөрчил буурна.

4.3.Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

4.3.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ өмнөх жилүүдэд иргэд, байгууллагад хийсэн сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүний тоог суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

	Хөтөлбөрийн зорилго, зорилт	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин		
			Суурь үзүүлэлт 2018 он	2019 он	2020 он
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт					
Зорилго	Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрх зүйн анхан шатны мэдлэгийг олгох, сургалт, сурталчилгаа, мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр хүргэх замаар иргэдэд хуулиар олгосон эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх чадвар, хандлага бий болгон төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.	Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо	15655	2 дахин нэмэгдүүлнэ.	3 дахин нэмэгдүүлнэ.
		Сургалтанд хамрагдсан иргэдийн тоо	6163 хүн	2 дахин нэмэгдүүлнэ.	3 дахин нэмэгдүүлнэ.
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт					
Зорилт 1	Иргэдэд эрх зүйн мэдлэг олгох албан болон албан бус сургалтуудыг тогтмол зохион байгуулах, эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэх	Сургалтын агуулга, хөтөлбөрийг батлагдсан арга зүйн дагуу хийдэг болсон байна.	-	Батлагдсан арга зүйн дагуу боловсруулж хэвшсэн байна.	Боловсронгуй болгож сайжруулна
		Сургалт, сурталчилгааны гарын авлага хэлбэр нь иргэдэд хүртээмжтэй байна.	-	Сурталчилгаа нь хүртээмжтэй болсон байна.	Аймгийн нийт хүн амын 60-аас доошгүй хувьд нь хүрсэн байна.

Зорилт 2	Хууль тогтоомжийг тайлбарлан таниулах сурталчилгаа мэдээллийн ажлыг үе шаттай явуулж, үр нөлөөг дээшлүүлэх, эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай техник, санхүү, хүний нөөцийг бүрдүүлэх, тогтсон мэдээллийн сувгуудыг бий болгон тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.	Эрх зүйн хөтчийн тоо	-	30-аас доошгүй	Бэлтгэгдсэн эрх зүйн хөтөчүүдийг байнга сургаж, дадлагажуулна
		Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны цахим хуудас ажилладаг болсон байна.	-	Орон нутгийн цахим хуудас ажиллуулж хэвшсэн байна.	Цахим хуудаст хандсан иргэд хүссэн газраасаа 100 хувь ашиглаж чаддаг болсон байна.
		Хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл авсан иргэдийн тоо	1525	Хүртээмж, үр дүнг сайжруулна.	Хүртээмж, үр дүнг сайжруулна.
Зорилт 3	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд олон талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулах	Эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох тогтмол нэвтрүүлэг, булан ажиллуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагын тоо		2	2
		Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа хийсэн, хамтран ажилласан төрийн байгууллагын тоо	17 сумын ЗДТГ	Засаг даргын дэргэдэх агентлагууд, ТББ-уудыг татан оролцуулна.	17 сумын ЗДТГ болон агентлагуудын иргэдэд чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг тогтмолжуулсан байна.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ

5.1.Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1.орон нутгийн төсөв;

5.1.2.гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламж;

5.1.3.хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах аймаг, сумын зөвлөлийг тухайн шатны Засаг даргын захирамжаар байгуулна.

6.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймаг, сумын зөвлөл нь холбогдох бусад байгууллагуудтай хамтран заалт бүрээр хэрэгжилтийг нь зохион байгуулах ба урьдчилан батлуулсан удирдамж, төлөвлөгөөний дагуу явуулна.

6.3.Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр эрх зүйн сургалт, сурталчилгаа хийх, судалгаанд оролцох, өөрийн байгууллагын ажилтан, албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

6.4.Төрийн байгууллага нь нутаг дэвсгэрийн болон байгууллагын хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд гаргах үүрэг хүлээнэ.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1.Нутаг дэвсгэрийн болон байгууллагын хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллагууд хийж хэрэгжүүлсэн ажил, хүрсэн үр дүнгийн тайлан мэдээг хагас, бүтэн жилээр жил бүрийн 06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлнэ.

7.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнг сум, байгууллагын жилийн ажлыг дүгнэх нэг үзүүлэлт болгоно.

7.3.Хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс жил бүр хяналт шинжилгээ үнэлгээ хийнэ.

7.4.Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах аймгийн зөвлөл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажлыг нэгтгэн дүгнэж Засаг даргын Зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлсний үндсэн дээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулна.

___ ооо ___

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 67 дугаар тогтоолын
2 дугаар хавсралт



“ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
/2019-2020 он/

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Хугацаа /он/		Хамрах хүрээ	Хариуцах эзэн	Төсөв /сая төг/
			2019	2020			
Нэг. Иргэдэд эрх зүйн мэдлэг олгох албан болон албан бус сургалтуудыг тогтмол зохион байгуулах, эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэх							
1	Эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны агуулгыг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр бэлтгэх, түгээх, хууль, эрх зүйн мэдээллийг гарын авлага, брошур, постер хэлбэрээр хүргэх	Иргэд хууль, эрх зүйн мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр авах боломж бий болно.	+	+	Иргэд	Хууль, эрх зүйн хэлтэс /цаашид ХЭЗХ/	1500,0
2	Эрх зүйн хөтчүүдийг бэлтгэх, сургалтанд хамруулах, хөтчүүдээр дамжуулан иргэд, байгууллагуудад мэдээлэл түгээх, сургалт зохион байгуулах /эрх зүйн хөтөчөөр аймгийн төвийн 12 багийн нийгмийн ажилтан, сумдын эрх зүйн ажилтнууд, Ховд Их сургуульд эрх зүйч мэргэжлээр суралцаж буй 1-2 оюутныг бэлтгэнэ/	Иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, сургалт зохион байгуулах үйл ажиллагааг бэлтгэгдсэн эрх зүйн хөтчөөр дамжуулан үр нөлөөг дээшлүүлнэ.	+	+	Иргэд	ЗДТГ, ХЭЗХ	2000,0
3	Иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан зорилтот бүлэгт тухайлбал, харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэн, өндөр настан, хүүхдэд ээлтэй, тэдгээрийн нас, сэтгэхүйн онцлог, нийтлэг болон тусгай хэрэгцээ шаардлагад нь тохирсон эрх зүйн боловсролын агуулгыг боловсруулах	Зорилтот бүлгийн иргэд хууль, эрх зүйн мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр авах боломж бий болно.	+		Зорилтот бүлгийн иргэд	ХЭЗХ, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Хууль зүйн туслалцааны төв	500,0

4	Хууль, захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шийдвэрийг бүрнээр нь болон хэсэгчлэн ангилсан байдлаар иргэдэд хүргэх, сурталчлах, эрх зүйн мэдээллийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Иргэдийн төрийн үйл ажиллагаа болон төрөөс гарах шийдвэрт саналаа оруулах нөхцөлийг бүрдүүлэх		+	Иргэд	ЗДТГ, ХЭЗХ	500,0	
5	Хууль зүйн туслалцааны төвөөс зорилтот бүлгийн иргэдэд эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, зорилтот бүлэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хууль зүйн туслалцааны чанар, хүртээмжийг сайжруулах	Зорилтот бүлгийн иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, тэдний эрх ашгийг хамгаална.		+	Зорилтот бүлгийн иргэд	Хууль зүйн туслалцааны төв	500,0	
Хоёр. Хууль тогтоомжийг тайлбарлан таниулах сурталчилгаа мэдээллийн ажлыг үе шаттай явуулж, үр нөлөөг дээшлүүлэх, эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай техник, санхүү, хүний нөөцийг бүрдүүлэх, тогтсон мэдээллийн сувгуудыг бий болгон тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.								
1	Эрх зүйн хөтчүүдийн ажлыг жилийн эцсийн байдлаар дүгнэн урамшуулж тэдний санал санаачилгыг дэмжих	Сургалт, сурталчилгааны ажлын үр дүн дээшилнэ. 30 эрх зүйн хөтчийг урамшуулна.		+	+	Иргэд	ХЭЗХ	6000,0
2	Телевиз, хэвлэлээр хүргэх хууль, эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, судалгааны материал, богино хэмжээний нэвтрүүлэг, шторк бэлтгэх	Эрх зүйн төрөл бүрийн асуудлыг яаж хэрхэн шийдвэрлэх талаар богино хэмжээний нэвтрүүлэг хийх, шторк, бусад хэлбэрээр мэдээлэл түгээж иргэдэд хүргэнэ.		+	+	Иргэд	ЗДТГ, ХЭЗХ, Орон нутгийн хэвлэлийн байгууллагууд	2000,0
3	Хууль, эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, зөвлөгөөний цахим хуудас ажиллуулах, эсвэл аймгийн сайтад хууль, эрх зүйн мэдээллийн булан ажиллуулж, мэдээлэл сурталчилгааг тасралтгүй хүргэх	Идэвхтэй хөгжиж буй сошиал мэдээллийн сувгуудыг ашиглаж илүү олон хүнд эрх зүйн мэдээ, мэдээллийг хүргэнэ.			+	Иргэд	ЗДТГ, ХЭЗХ	500,0
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, хүүхдэд эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх хүний нөөц	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, хүүхдэд		+		Зорилтот бүлгийн иргэд	ЗДТГ, ХЭЗХ	500,0

	(дохионы хэлний хэлмэрч, сэтгэл зүйч)-ийг бэлтгэх ажилд холбогдох байгууллагад нь дэмжлэг үзүүлэх /мэдээ мэдээллээр хангах/	эрх зүйн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.					
5	Сумдын Засаг даргын Тамгын газрын эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах, сургалтанд хамруулах, мэргэжил, арга зүйгээр хангах	Сумдын эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлнэ.	+	+	Эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүд	ЗДТГ, ХЭЗХ	2000,0
Гурав. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд олон талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулах							
1	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр орон нутгийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх	Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа дээшилж, иргэдэд очих төрийн үйлчилгээ сайжирна.	+		Төрийн байгууллагууд	ЗДТГ, ХЭЗХ	
2	Эрх зүйн болон хүний эрхийн сургалт, сурталчилгаанд орон нутгийн төрийн байгууллагууд, Хууль зүйн туслалцааны төвийн орон нутаг дахь салбар болон бусад холбогдох этгээдийн оролцоог нэмэгдүүлэх, чиглэл өгөх, үйл ажиллагааг уялдуулах	Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа дээшилж, иргэдэд очих төрийн үйлчилгээ сайжирна.	+		Төрийн байгууллагууд	ЗДТГ, ХЭЗХ	
3	Эрх зүйн мэргэжлээр сургалт явуулж буй Ховд их сургууль болон төрийн бус байгууллагуудын дэргэдэх хууль зүйн клиник төвөөс иргэдэд эрх зүйн болон хүний эрхийн анхан шатны зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, эрх зүйч мэргэжлээр сурч буй оюутнуудын эрх зүйн хөтчөөр ажиллах сайн дурын үйл ажиллагааг бүх талаар дэмжих	Эрх зүйч мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг дэмжих, дадлагажуулах, тэднийг эрх зүйн хөтчөөр бэлтгэх, урамшуулах үйл ажиллагааг зохион байгуулна.	+	+	Эрх зүйн мэргэжлээр суралцагч оюутнууд	ЗДТГ, ХЭЗХ	1000,0
4	Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын үр дүнг тооцох, иргэдийн дунд судалгааны ажлыг зохион байгуулах, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог хангах	Төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагаа өргөжнө. Хөтөлбөрийн үр дүнг тооцно.		+	Иргэд, байгууллагууд	ХЭЗХ	500,0
5	Бүх нийтийн эрх зүйн мэдлэгийг	Эрх зүйн болон хүний	+		Хувийн	ЗДТГ, ХЭЗХ	500,0

	дээшлүүлэхэд үүрэн холбооны аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг хариуцлагыг өндөржүүлж, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх зүйн болон хүний эрхийн мэдээлэл, сурталчилгааны ажилд оролцохыг бүх талаар дэмжих	эрхийн мэдээлэл, сурталчилгааны ажилд оролцох байгууллагуудыг дэмжиж хамтран ажиллана.			хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагууд		
6	Тодорхой түвшний эрх зүйн мэдлэг эзэмшсэн хамт олон болж, үүнийгээ үнэлүүлэн баталгаажуулахад чиглэсэн санал, санаачилга өрнүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Эрх зүйн мэдээлэл сурталчилгааны ажилд идэвхтэй оролцдог байгууллага, хамт олныг дэмжиж сурталчлан хамтран ажиллана.		+	Байгууллагууд	ЗДТГ, ХЭЗХ	1000,0
7	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжигч, бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох үүргээ сайн хэрэгжүүлсэн байгууллага, хамт олныг сурталчлах, алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулах	Эрх зүйн мэдээлэл сурталчилгааны ажилд идэвхтэй оролцдог байгууллага, хамт олныг дэмжиж сурталчилна. Сайн туршлага бий болно.		+	Байгууллагууд	ЗДТГ, ХЭЗХ	1000,0
							20,000,0